# БАЯНХОНГОР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## БАЯНХОНГОР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

**2024 оны 05 дугаар сарын 31** **Рашаант**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэсл эж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /I-IV улирал/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛГО:УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ. /"Алсын хараа -2050" зорилт 5.3,"Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 5.3, "МУ-ын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.1.1,Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө/** | | | | | | | |
| **Зорилт 1.Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.** | | | | | | | |
| 1.1 | Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилгын засварын ажлыг хийж, албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах | Улсын төсөв 911. 0 сая/төг | Барилгын засварын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 2022 онд Баянхонгор аймагт Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ахлуулсан ажлын хэсэг ажиллах үеэр хүсэлт тавьснаар 2022 онд зураг төсөв нь хийгдэж, 2024 онд тус сайдын багцаас хийхээр шийдвэрлэгдсэн дагуу 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс барилгын их засварын ажил эхлэн явагдаж байна. Тус барилгын их засварын ажлын төсөвт өртөг нь 911,4 сая төгрөг, засварын ажлын гүйцэтгэл 70 гаруй хувьтай байна. | 70 |
| 1.2 | Тоон гарын үсэг олгох ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах | - | Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн хувь | 74,5 | 100 | 2024 оны 1 дүгээр сараас 5 сарын 31-ний өдрийн байдлаар 6807 олгогдож 85,9 хувьтай боллоо. | 85,9 |
| 1.3 | Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээ хийх | - | Бүртгэлийн үйлчилгээнд | - | 2 | Хугацаа болоогүй. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дүн шинжилгээ хийсэн тоо | | | | |
| 1.4 | Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шинэчлэн боловсруулах шаардлагатай дүрэм, журмын төсөлд санал хүргүүлэх | - | Эрх зүйн актын төсөлд санал хүргүүлсэн тоо | 4 | 4 | Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Тамгын газрын 2023 оны 12 сарын 15-ны өдрийн 2/11956 тоот “Санал авах тухай”, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 12 сарын 12-ны өдрийн 5/11711 тоот “Санал ирүүлэх тухай”, УБЕГ-ын даргын 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 1125 дугаар “Загвар, журам шинэчлэн батлах тухай” тушаалын хавсралтад, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын 2024 оны сургалтын төлөвлөгөөнд санал авах тухай,<br>Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны дэмжлэгтэй хэрэгжүүлэх төслийн хүрээнд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн системийг шинэчлэхэд шинэ системд тусгах санал авах тухай албан бичгүүдэд<br>Хуулийн этгээдийн бүртгэлийн газар 1/50, 1/90, 1/126, Тамгын газар 1/318, БДТШГ-т 1/321 тоот албан бичгээр тус тус хугацаанд нь хариу хүргүүлэн ажиллалаа. | 100 |
| 1.5 | Баянхонгор сумын хилийн цэсийн өөрчлөлтийн дагуу иргэдийн хаягийн өөрчлөлтийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд өөрчлөх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах | - | Баянхонгор сумын хилийн цэсийн өөрчлөлтийн дагуу иргэдийн хаяг шинэчлэгдсэн хувь | 60 | 100 | Энэ талаар УБЕГ-т албан тоот хүргэснээр ИУБГ-тай онлайн уулзалт хийж мэдээллийн санд хаяг нь өөрчлөгдөх иргэдийн нэгдсэн мэдээлэл судалгааг нарийвчлан гаргаж ирүүлэхийг чиглэл өгсөн дагуу бэлтгэл ажлыг сонгуулийн ажлын дараагаар ажиллахаар төлөвлөн ажиллаж байна. | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.6 | Бүртгэлийн үйлчилгээг мэдээллийн технологийн арга хэрэгслээр үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх | - | Улсын бүртгэлийн цахим машинаар үзүүлсэн үйлчилгээний тоо | 3500 | 4500 | Тус хэлтэст 2022 оны 3 сард бүртгэлийн Дөт киоск машиныг байршуулан иргэдэд үйлчилж байгаа ба 2024 оны 1 дүгээр сараас 5 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 2476 лавлагаа үйлчилгээ үзүүлсэн байна. | 55,02 |
| 1.7 | Улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх зорилгоор контент бэлтгэж, түгээх | | -Бэлтгэсэн Контентын тоо | 2 | 8 | Улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх зорилгоор контент бэлтгэж, түгээх гэсэн 2 үндсэн арга хэмжээг тус тус төлөвлөн оруулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 5 сарын 31-ний өдрийн байдлаар хэлтсээс 11 контент, 23 постер мэдэлэл бэлтгэж байршуулаад байна. | 100 |
| **Зорилт 2.Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний чанар хүртээмж, түргэн шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| 2.1 | Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөтлөх | - | Иргэний улсын бүртгэл хөтөлсөн хувь | 100 | 100 | Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр нийт 9750 бүртгэлийг бүртгэн баталгаажуулсан байна.<br>2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар эд хөрөнгийн нийт **4408** бүртгэлийн мэдүүлэг хүлээн авч, холбогдох бүртгэлийг Улсын бүртгэлийн хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөтлөн бүртгэж, цахимжуулан хадгалж байна.<br>Тайлант хугацаанд хуулийн этгээдийн нийт 478 бүртгэл бүртгэгдсэн байна. Үүнээс шинээр бүртгэгдсэн хуулийн этгээд 171, хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн бүртгэл, | 100 |
| | | | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлсөн хувь | 100 | 100 | | |
| | | | Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтөлсөн хувь | 100 | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | лавлагаа, тамга тэмдэг сольсон нийт 306, татан буугдсан бүртгэл 1 хөтөлсөн байна. | |
| 2.2 | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг цэгцлэх, тулгалт хийх ажлыг үе шаттайгаар хийх ажлыг үргэлжлүүлэх | - | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд зөрүүтэй орсон, алдаатай орсон мэдээллийг засч оруулсан тоо; | 1183 | 1200 | Тайлант хугацаанд Хяналтын улсын байцаагч Л.Мэндбаярын 2024-04-12-ны өдрийн 1567 дүгнэлт, мөн 2024-02-23-ны өдрийн 766 тоот дүгнэлт, УБЕГ-ын ХУАБ-ийн 2022-03-02-ны өдрийн 1500 дүгнэлтээр хувийн хэргийн цахимжуулалтад болон цаасан нотлох баримтад нийт 24 хувийн хэрэгт засвар өөрчлөлт оруурж, гарсан алдаа зөрчлийг арилгасан болно. | 100 |
| 2.3 | Улсын бүртгэлийн байгууллагаас мэдээлэл, лавлагаа өгөх | - | -Иргэнд олгосон тоо | 2119 | 2200 | Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлд зааснаар эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 84, Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр төрийн байгууллагад олгосон лавлагаа 19, хуулбар 8, иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 4886 лавлагаа тус тус олгосон байна. | 100 |
| | | | -Хууль хяналтын байгууллагад олгосон тоо | 1164 | 1200 | | |
| 2.4 | Сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг үргэлжлүүлэх, нэмэгдүүлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг эхлүүлэх | - | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж буй сумдын тоо; | 2 | 5 | Сумын улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх олгох тухай тушаалын дагуу Баянхонгор аймгийн 6 сумын бүртгэгчдэд эд хөрөнгийн бүртгэлийн эрх нээгдсэн ба нийт 8 сум эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр иргэдэд мэдээлэл өгч ажиллаж байна.<br>Хуулийн этгээдийн бүртгэлийн эрх нэмж олгуулах албан тоот судалгааг УБЕГ-т хүргүүлсэн | 100 |
| | | | Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг | - | 1 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үзүүлж буй сумын тоо | | | боловч одоогоор тушаал гарч эрх олгогдоогүй 3 албан хаагч бүртгэл хийж байна. | |
| 2.5 | Нотариатч мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр хуулийн шаардлага хангасан мэдүүлэг холбогдох баримт бичгийг улсын бүртгэлийн мэдээллийн санд илгээх, бүртгүүлэхэд зуучлах үйлчилгээг нэвтрүүлэх. | - | Мэдээлэл нийлүүлэх, авах гэрээг байгуулсан нотариатчдын тоо | 0 | 1 | Баянхонгор аймгийн хэмжээнд тойргын 3 нотариатч ажилладаг ба 2 Нотариатч нь мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр хуулийн шаардлага хангасан мэдүүлэг холбогдох баримт бичгийг улсын бүртгэлийн мэдээллийн санд илгээх эрхтэй болсон байна.<br>Үүнтэй холбогдуулан нотариатч нартай уулзалт зохион байгуулан эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 2 удаа танхимаар, бусад тохиолдолд утсаар байнга мэдээлэл солилцон уялдаатай ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар эрхийн улсын бүртгэлийн байгууллагад мэдүүлэг ирүүлээгүй байна. | 100 |
| | | | Нотариатаар зуучлуулан эрхийн улсын бүртгэлд бүртгүүлсэн бүртгэлийн тоо | 0 | 2 | | |
| 2.6 | Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сан байгуулах, өөрчлөлт оруулах, хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх | - | -газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сангийн өөрчлөлт оруулсан хувь | 0 | 10 | Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд Баянхонгор аймгийн Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газраас ирүүлсэн хаягийн тодорхойлолт, кадастрын зураг, газрын гэрчилгээний хуулбар зэргийг үндэслэн 19 хаягийг мэдээллийн санд нэмж оруулсан. | 50 |
| | | | - хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн хувь | 0 | 10 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.7 | Аймгийн хэмжээнд улсын бүртгэлийн явуулын үйлчилгээгээр үзүүлэх үйлчилгээний тоог нэмэгдүүлэх | - | 4G төхөөрөмжийн тоо | 2 | 3 | Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, зорилтот бүлгийн иргэдэд хүрч үйлчлэх зорилгоор “Явуулын үйлчилгээ” үзүүлэхээр УБЕГ-т хөдөлгөөнт төхөөрөмж хүсэн 2024 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 1/42 тоот албан бичгийг хүргүүлснээр нэмж 1 төхөөрөмж авч хэлтсийн төв 2 боллоо. Өлзийт сум 1 төхөөрөмжтэй. Үйлчилгээний тоо 668 үйлчилгээг үзүүлэн ажиллав. | 100 |
| | | | Үзүүлсэн үйлчилгээний тоо | 1587 | 3000 | | |
| 2.8 | “Бүртгэлийн үйлчилгээг Бямба garagт” төлөвлөгөө гарган ажиллах | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 100 | Төлөвлөгөөг нийт 2 зорилтын хүрээнд 5 ажил үйлчилгээ үзүүлэхээр батлан хэрэгжүүлж байна. | 40 |
| | | | 24/7 үйлчилгээний хүрээнд тус гарагт киоскоор үзүүлсэн үйлчилгээний тоо | - | 250 | Коискоор нийт 2476 үйлчилгээг үзүүлснээс Бямба гарагт үзүүлсэн үйлчилгээ 100 орчимд хүрч байсан бол 4 дүгээр сарын 1-ээс хэлтсийн байрны их засвараас шалтгаалан өөр байранд үйлчилгээ үзүүлж байгаа тул Бямба гараг үйлчилгээ үзүүлэх боломжгүй болсон. | 100 |
| 2.9 | Иргэний улсын бүртгэлийн баримтыг цахимжуулах | - | Хуудасны тоо | 26123 | 100 | Иргэний улсын бүртгэлийн баримтыг цахимжуулалт эхний хагас жилийн байдлаар 20400 хуудас нотлох баримтыг бүрэн хамжуулаад байна. | 100 |
| **Зорилт 3. Улсын бүртгэл болон улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулна**. | | | | | | | |
| 3.1 | Хяналт шалгалтын төлөвлөгөө батлан, хэрэгжилтийг хангах | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь; | 87,5 | 100 | Хяналтын шалгалтын төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 9 арга хэмжээг төлөвлөн батлан хэрэгжүүлж байна. Тайлант хугацаанд төлөвлөгөөт шалгалт 2, гэнэтийн болон | 55,5 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвлөгөөт бус шалгалт 2 хийгдэж 2160 бүртгэлийг хамруулсан. Өргөдөл, санал, гомдлын мөрөөр хийсэн шалгалт-55 байна. | |
| 3.2 | Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэдийн зөрчлийг арилгах | - | -Зөрчлийг арилгасан хувь | 70 | 100 | Тайлант хугацаанд нийт мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн 640 иргэний мэдээллийг засварлаж зөрчлийг арилгалаа. | 100 |
| 3.3 | Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулж батлан, хэрэгжүүлж ажиллах | - | - Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь. | 80 | 100 | Зөрчлөөс урьдчилсан сэргийлэх ажлын төлөвлөгөөнд нийт 6 ажил тусгагдсанаас 3 ажлыг хийж гүйцэтгэлээ. 3 ажил нь хугацаа болоогүй хүлээгдэж байна.<br>1.Улсын бүртгэгч нарт “Зөрчлөөс урьдчилан сэргийлэх бүртгэлийн болон бусад холбогдох хууль тогтоомжийн талаар нэг мөр ойлголттой болох” сэдэвт 1 удаагийн танхимын сургалт хийж, нийт албан хаагчид бэрэн хамрагдав. Аймгийн Удирдлагуудын шуурхай мэдээллийн цагаар Зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь сэдвээр 1 удаа мэдээлэл өгөв. Сумдын улсын бүртгэгч нарт урьдчилан сэргийлэх постер контент бэлтгэх чиглэлийн дагуу 8 бүртгэгч мэдээлэл бэлтгэснийг хэлтсийн цахим хуудсуудад байршуулан түгээж байна.<br>2.Аймгийн төвөөс бусад 19 сумдын улсын бүртгэгч нарт үүрэг чилгэл өгч 2024 онд 16, 25, 45 нас болон төрөлт, нас баралт, гэрлэлт цуцлалт зэрэг хуульд заасан хугацаанд бүртгүүлэх бүртгэлүүдийг хугацаандаа бүртгүүлэх талаар 1 удаагийн онлайн сургалт хийлээ. 3.Аймгийн Багийн | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Засаг дарга нартай хамтарч Улсын бүртгэлийн болон Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Аймгийн төвийн 1, 10 дугаар багийн Засаг дарга, нийгмийн ажилтнуудтай хамтарч 2024 онд 16, 25, 45 нас болон төрөлт, нас баралт, гэрлэлт цуцлалт зэрэг хуульд заасан хугацаанд бүртгүүлэх бүртгэлүүдийг хугацаандаа бүртгүүлэх талаар иргэдэд мэдлэг, мэдээлэл хүргэн ажиллаж байна. | |
| **Зорилт 4. Улсын бүртгэлийн байгууллагын удирдлагын менежмент, хүний нөөцийн төлөвлөлтийг сайжруулж, мэргэжлийн боловсон хүчний чадавхыг дээшлүүлнэ.** | | | | | | | |
| 4.1 | “Хэлтсийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөө 2024”–ыг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь; | 87,09 | 100 | Хэлтсийн сургалтын төлөвлөгөөг хагас бүтэн жилээр батлан хэрэгжүүлдэг. Эхний хагас жилийн байдлаар хэлтсийн дотоод сургалт нийт 10 удаагийн сургалт мэдээллийн цаг орохоор төлөвлөсөн нь бүрэн хэрэгжиж сургалт зохион байгуулагдсан. Хэлтсийн албан хаагчдын нэгдсэн сургалтыг мөн тусгай хөтөлбөр батлан хэрэгжүүлж 4 дүгээр сарын 18-19-ний өдөр зохион байгуулж ирц 100 хувьтай оролцсон бол сүүлийн хагас жилийн сургалтын төлөвлөгөөнд 8 удаагийн сургалтыг төлөвлөсөн байна. | 100 |
| 4.2 | Албан хаагчдын нийгмийн баталгаа хангах хөтөлбөр, төлөвлөгөөний холбогдох заалтыг хэрэгжүүлэх | - | Хэрэгжилтийн хувь | 91,94 | 100 | “Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр” 2023 оны 05 дугаар сарын 4-ний өдөр батлагдаж ирсэн. Төлөвлөгөөг нийт албан хаагчдад уншиж танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нийт 5 арга хэмжээнээс 2024 оны явган алхалт, аялал хийх ажил арга хэмжээ, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах арга хэмжээ, ажилтнуудад газар олгуулах арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна. | |
| 4.3 | Хэлтсийн албан хаагчдын холбогдох судалгааг УБЕГ-т хүргүүлэх | - | Хүргүүлсэн судалгааны тоо | 5 | 7 | 2024 оны 1/245, 1/273, 1/313,1/324 тоот албан бичгүүдээр холбогдох судалгаануудыг edoc системээр хүргүүлсэн байна. | 100 |
| **Зорилт 5. Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, гүйцэтгэлд нь хяналт тавих, тайлагнах** | | | | | | | |
| 5.1. | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хяналт тавих | - | -Ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь; | 86,2 | 90,0 | Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу байгууллагад ирсэн өргөдлийг бүртгэлжүүлэн хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна. 2024 оны 5 сарын 31-ний өдрийн байдлаар 10 өргөдөл ирсэн. Үүнээс бүрэн шийдвэрлэсэн 9, шийдвэрлэх шатандаа 1 өргөдөл байна. Өргөдөл гомдлын мэдээ, тайлан үнэн зөв гарган улирал тутам аймгийн Төрийн захиргаа удирдлагын хэлтэст мөн УБЕГ-ын холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажиллаж байна | 90 |
| 5.2 | Хэлтсийн албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн эргэлтэд хяналт тавих | - | -Хугацаатай хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн хувь; | 90 | 100 | Хэлтсийн хэмжээнд 2024 оны 05 дугаар сарын 31-ний байдлаар ирсэн албан бичиг 440, Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын даргын тушаал, чиглэл, зөвлөмж , дотоод албан бичиг нийт 40 тус тус бүртгэгдсэн байх ба хэлтсээс 336 албан бичиг явуулсан байна.<br>Ирсэн, явсан албан бичиг болон өргөдөл, гомдлыг скайнердэж **Able** программ дээр бүртгэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хяналтын карт хөтлөн хяналт тавин ажиллаж байна. Хэлтэст нийт 278 **хариутай албан бичиг ирүүлсэн ба** хуулийн хугацаа хэтрүүлэн хариу илгээсэн албан бичиг байхгүй болно. Удирдлагаас гарах шийдвэрийн болоод зохион байгуулалтын баримт бичиг буюу Хэлтсийн даргын тушаал 15, хамт олны хурлын тэмдэглэл 3 гарсан байна. | |
| 5.3 | Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих | - | Үйлчилгээний стандартын хэрэгжилтийн хувь; | 90 | 100 | Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөн ажиллахыг анхааруулж байнгын хяналт тавин ажиллаж байна. Ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар ямар нэгэн зөрчил илрээгүй, гомдол мэдээлэл ирээгүй байна. Үйлчилгээний стандарт мөрдөлтийн явцын талаар сар бүрээр нэгтгэж хамт олны мэдээллийн цагт 5 удаа танилцуулж хэрэгжүүлэхийг үүрэг болгон ажиллаж байна.Үйлчилгээний стандартын хэрэгжилтийг тооцож үзэхэд 92 хувьтай байна. | 92 |
| 5.4 | УБЕГ-ын Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын бүртгэл хөтөлж, хэрэгжилтийг хангаж ажиллах | - | Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь | 90 | 100 | УБЕГ-ын даргын зөвлөлийн, мөн өргөтгөсөн хурлаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр нь хүлээн авч хэрэгжилтийн ханган ажиллаж байна. Тамгын газрын даргын шуурхай цахим хуралд тухай бүр нь бүрэн оролцсон. Үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь ochirbat@burtgel.gov..mn хаягаар хүргүүлэн ажиллаж байна. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.5 | Байгууллагын нууцын ажлыг Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах | - | Нууцын баталгаа авсан хувь | 100 | 100 | 2024 оны гарсаар хэлтсийн нийт албан хаагчдаас гүйцэтгэж буй ажил үйлчилгээтэй холбоотойгоор нууцын баталгааг нийт 39 албан хаагчаас гаргуулан авсан.2023 оны байгууллагын нууцын тайланг аймгийн Тагнуулын хэлтэст хугацаанд хүргүүлсэн. 2024 оны 4 сард шинээр томилогдсон 1, хүүхэд асрах чөлөө дуусгавар болгож ажилдаа орсон1, түр орлонгоор томилогдсон 1 албан хаагчаас нууцын баталгааг гаргуулан авч хууль тогтоомжийг тайлбарлан таниулж уншиж судлах үүргийг өгсөн болно.<br>Нууцын тухай хууль тогтоомжоор сургалт мэдээлэл 1 удаа хийсэн байна. | 100 |
| 5.6 | Байгууллагаас сар бүр үзүүлсэн үйлчилгээний талаар инфографик мэдээлэл бэлтгэх, олон нийтэд хүргэх | - | Сар бүрийн тоон мэдээг байршуулсан тоо | 12 | 12 | Улсын бүртгэлийн ерөнхий газарт сар бүрийн тоон мэдээг тухай бүр нь үнэн зөв гаргаж хугацаанд нь хүргүүлж нэгтгүүлсэн. Мөн Хэлтсийн bayankhongor.burtgel.gov.mn вэйб хаягийн сар бүрийн тоо мэдээ цэст болон хэлтсийн мэдээллийн самбарт 6 удаа байршуулсан болно. | 100 |
| 5.7 | Байгууллагын үйл ажиллагааг цахим, фэйсбүүк хуудсаар болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, телевиз радиогийн нэвтрүүлэгт оролцох | - | Сурталчилсан хэвлэл мэдээллийн хэрэгслийн төрлийн тоо | 3 | 4 | -2024 оны 5 сарын 31-ны өдрийн байдлаар хэлтсийн жилийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг https://bayankhongor.burtgel.gov.mn/ сайт болон байгууллагын facebook page хуудсуудаар дамжуулан иргэдэд түгээж байна. Мөн | 100 |
| | | | Олон нийтэд сурталчилсан | 379 | 400 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдээ, мэдээллийн тоо | | | бүртгэлүүдийн талаар шинэ гарын авлага, болон шинэ мэдээ мэдээллийг байршуулан ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар 31 үйл ажиллагааг сурталчлан байршуулсан байна. Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс гэсэн фэйсбүүк пэйж хуудсанд 176 удаагийн мэдээ мэдээллийг тавьж байршуулан иргэд олон нийтэд сурталчилж хамгийн олон хандалт авсан мэдээ мэдээлэл нь Шилжилт хөдөлгөөний бүртгэл зогсоох болон Хэлтсийн байрны засвартай холбоотой шилжин ажиллах зар мэдээлэл, Өглөөний цай уулзалтыг зохион байгуулсан мэдээллүүд тус тус байна<br><br>- Аймгийн ЗДТГ-ын хэвлэл мэдээллийн алба болон орон нутгийн Номгон TV-ээр мэдээлэл өгч олон нийтэд цацуулсан нэвтрүүлгийг 1 удаа хийлгэсэн. | |
| 5.8 | Улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулах | - | “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулсан тоо; | 4 | 8 | Нээлттэй хаалганы өдөрлөг арга хэмжээг эхний хагас жилд 2 удаа буюу Баянговь, Жаргалант сумдад зохион байгуулсан. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг хэлтсийн бичмэл тайланд тусгасан болно. | 50 |
| 5.9 | Аймгийн ИТХ, Засаг дарга болон төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж дэмжлэг авах | Орон нутгийн төсөв | Санал тавьж шийдвэрлүүлсэн тоо | 1 | 2 | Хэлтсээс Бага оврын дизель мотор шийдвэрлэж өгөх хүсэлтийг хүргүүлэн 2023 оны 12 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд болсон аймгийн ИТХ-ын хуралдаанаар батлагдсан Аймгийн 2024 оны хөгжлийн | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвлөгөөнд 15,0 сая төгрөгийн хөрөнгийг тусган шийдвэрлүүлсэн. Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний дагуу бага оврын дизель генераторыг худалдан авахаар холбогдох компаниудад хандахад 100квт чадалтай генератор нь 30,0 сая төгрөгийн өртөгтэй тул 15.0 сая төгрөгөөр худалдан авах боломжгүй байна. Иймд үлдэгдэл 15,0 сая төгрөгийг төсвийн тодотголоор шийдвэрлүүлэхээр саналыг аймгийн ЗДТГ-ын ХБХОХ-т 1/319 тоотоор хүргүүлээд байна. | |
| 5.10 | Байгууллагын тусгай төрлийн баримтыг Төрийн архивт шилжүүлэх | - | Баримтыг заасан хугацаанд бүрэн шилжүүлсэн шилжүүлсэн баримтын тоо | 0 | 1 | Хугацаа болоогүй. | |
| **Зорилт 6. Санхүү, төсвийн удирдлага болон төсвийн гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 6.1 | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулах, тайлагнах, байршуулах | - | Хугацаандаа байршуулсан шилэн дансны мэдээллийн тоо | 145 | 147 | Улсын бүртгэлийн хэлтэс нь 2024 оны 05 сарын 30-ны байдлаар улсын төсвөөс 561.633.8 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авч цалин хөлсний зардалд 434.418.4, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 63.827.1, гэрэл цахилгааны зардалд 1.204.7, түлш халаалтын 30.000.0, цэвэр бохир усны зардалд 950.4, бичиг хэргийн зардалд 4.766.5, тээвэр шатахууны зардалд 1.183.5 шуудан холбооны зардалд 1.034.2, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардалд 600.0, багаж техник хэрэгслийн зардалд 335.0, хөдөлмөр хамгааллын хэрэглэлийн зардалд 200,0, мэдээллийн технологийн зардалд 990.0, хичээл | 100 |
| | | | Хугацаандаа хүргүүлсэн хувь | 98,6 | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлдвэрлэлийн зардалд 400.0 мянган төгрөг зарцуулж улсын төсвийн орлогын дансанд үндсэн үйл ажиллагааны орлого 60.615.5 мянган төгрөгийг улсын төсвийн дансанд төвлөрүүлэн ажиллаж байна.<br>Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын тогтоолын дагуу байгууллагын санхүүгийн мэдээллийг www.shilendans.gov.mn, сайтад сар бүр тогтмол байршуулан 56 удаагийн мэдээлэл шинэчилж, www.bayankhongorburtgel.com сайтад тогтмол байршуулан 5 удаагийн мэдээлэл шинэчилж ажилласан. | |
| 6.2 | Байгууллагын хэвийн үйл ажиллагаа болон дараа жилийн зорилтыг хангахуйц төсвийг төлөвлөх, хүргүүлэх, батлуулах | | Хугацаандаа хүргүүлсэн хувь | 100 | 100 | Байгууллагын 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг хуулийн хугацаанд гарган УБЕГ-т хүргүүлэхээр бэлтгэгдэж байна. | 80 |
| **Зорилт 7. Хуулиар олгосон тусгай чиг үүргийг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 7.1 | МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг ханган ажиллах. | | Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хувь | 100 | 100 | Хэлтсийн сонгуулийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг 39 ажил арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар хэрэгжилт 74,3 хувьтай хэрэгжиж байна. | 74,3 |
| 7.2 | Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг ханган ажиллах | | Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хувь | 100 | 100 | Одоогийн байдлаар 20 сумдын ИТХ-ын сонгуулийн хэсэг байгуулсан тухай тогтоол шийдвэрүүдийг хүлээн авч хянах ажил хийгдэж байна. Ерөнхий төлөвлөгөө хараахан батлагдаж ирээгүй, мөн хуулийн хугацаа болоогүй байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 8. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 8.1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | - | АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд хүргэсэн тоо | 11 | 18 | АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд мэдээлэл 7 удаа байршуулж түгээсэн байна. | 70 |
| | | | АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг байгууллагын хэмжээнд зохион байгуулсан тоо | 2 | 2 | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс ирүүлсэн удирдамжийн дагуу 2 удаагийн аянд оролцож байна. Дүгнэх хугацаа болоогүй болно. Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хуулийн этгээдийн улсын бүртгэгч Д.Отгонсүрэн хариуцан хэрэгжилтийг ханган биелэлтийг холбогдох газруудад хүргэн ажиллаж байна. | |

---------оОо-------

ЦАХИМ ГАРЫН ҮСЭГ БАТАЛГААЖЛАА

| | |
|---|---|
| Байгууллагын нэр: | **Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс** |
| Газар хэлтэс: | **Захиргаа** |
| Албан тушаал: | **Дарга** |
| Овог нэр: | **Цэдэндамба Мөнхжаргал** |
| Зурсан огноо: | **2024,06,15** |